

**DPUB2**  
Монгол Улс  
дахь ХБИ-ийн  
хөдөлмөр  
эрхлэлтийг  
дэмжих  
тогтолцоог  
бэхжүүлэх  
төсөл

# DPUB2 МЭДЭЭ

№ 08  
2022 оны Наймдугаар сар

## 1. ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх давтлага сургалтыг зохион байгууллаа

DPUB 2 төслийн баг 10-р сард зохион байгуулагдах ААНБ-уудад зориулсан нөлөөллийн семинарт бэлтгэн ажиллаж байна. Давтлага сургалтын хүрээнд 8-р сарын 5-ны өдөр Х. Мөнхтуул, Г. Эрдэнэзул нар “ААНБ-уудад үзүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэ цэнэ”, “ААНБ дахь тохирох хэрэглэгдэхүүний жишээ” гэсэн хоёр лекцийг танилцуулж, сургуулилт хийлээ.

Лекц тавьсан хоёр оролцогч сургалтын агуулгад багтсан мэдээллийг өөрийн болгох, хугацаандаа багтааж лекцээ ярих зэрэг Япон улсын Мираиро компаний багш нарын өгсөн зөвлөгөөний дагуу бэлдсэн байв.

Дараагийн давтлага сургалт 8-р сарын 16-нд болох ба оролцогч Д. Батзаяа, Р. Сарантуяа, Н. Тэмүүлэн нар тус бүр “ААНБ-уудад үзүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэ цэнэ”, “ААНБ дахь тохирох хэрэглэгдэхүүний жишээ”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэмжлэг үзүүлэх” гэсэн сэдвээр лекцийг танилцуулна. Мөн Мираиро компаний багш нар мэргэжлийн үг хэллэг болон гол агуулгын талаар тайлбарлах болно. Та бүхэн бидэнтэй хамт байж манай мэдээллийг цаг алдалгүй аварай!



Г. Эрдэнэзул лекцээ тавьж танилцуулж байна

## 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэмжлэг үзүүлэх нь дасгал ажлыг удирдах гишүүдтэй уулзлаа



Хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх практик дасгал ажлыг чиглүүлэх гишүүд уулзаж байна

8-р сарын 24-ний өдөр DPUB2 төслийн Япон мэргэжилтэн нөлөөллийн багийн гишүүдтэй уулзаж “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах/дэмжлэг үзүүлэх” практик дасгал ажил болон сургалтын арга, агуулгын талаар ярилцав.

Хараагүйчүүдийн үндэсний холбооны Ш. Оюунбат харааны бэрхшээлтэй хүнд хөтөч хийх болон хэрхэн дэмжлэг үзүүлэх үйл явцын талаар голлон ярилцлаа.

Харин “Түгээмэл Хөгжил” төв нь тэргэнцэр ашигладаг хөдөлгөөний бэрхшээлтэй хүнд дэмжлэг үзүүлэх

практик сургалтыг Монгол улсад хийдэг арвин туршлагатай бөгөөд тус сургалтыг удирдан явуулдаг Ц. Лхамжав, Н. Мөнхжаргал нартай санал солилцлоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийн хэрэгцээ, шаардлага ондоо. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд тухайн хүнээс нь ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар асуух зэргээр харилцаа үүсгэх нь чухал гэсэн санааг сургалтын агуулгад багтаах дээр санал нэгдэв.

СЭДЭВ

1 ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх давтлага сургалтыг зохион байгууллаа

2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэмжлэг үзүүлэх нь дасгал ажлыг удирдах гишүүдтэй уулзлаа

✉ [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)

📍 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5

🌐 <https://www.facebook.com/jicadpub1and2>

🌐 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>